



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Байгууллагын зөвлөгөө, мэдээллийн
1800-1882 утасны дуудлагад хариу
өгөх ажлыг эрчимжүүлэх тухай”

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, 42.2.2 дахь заалт, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалтыг үндэслэн байгууллагаас үзүүлж буй зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг чанаржуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга, албан хаагчдад ДААЛГАХ нь:

- 1.Хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн албан хаагчдад
 - 1.1. Байгууллагын зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 утас (цаашид “зөвлөгөө, мэдээллийн утас” гэх)-аар үйлчлүүлэгчид зөвлөгөө, мэдээлэл өгөхдөө дуудлага бурд товч тодорхой, бүрэн хариултыг өгч, зөв боловсон, ёс зүйтэй харилцах;
- 2.Хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт
 - 1.2. Зөвлөгөө, мэдээллийн утасны шугамыг хариуцаж буй албан хаагч өөр ажил, үүрэг гүйцэтгэх тохиолдолд орлон ажиллах албан хаагчийг нэн даруй томилж, хэвийн үйл ажиллагааг хангах;
 - 1.3. Үйлчлүүлэгчид буруу мэдээлэл өгсөн, зөвлөгөө, мэдээллийн утасны дуудлагад хариу өгөөгүй, ёс зүй, харилцааны доголдол гаргасан албан хаагчийн талаарх гомдол мэдээллийг судалж, шалтгаан нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;
 - 1.4. Албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлэхдээ хуваарьт хугацаанд хариу өгсөн дуудлагын тоо хэмжээ, чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, мэргэшлийн ур чадвартай холбогдох үзүүлэлтийг харгалзах
- 3.Үйлчлүүлэгчид буруу мэдээлэл өгсөн, хандлага, харилцааны зөрчил гаргасан, хуваарьт хугацаанд дуудлагад хариу өгөөгүй албан хаагчид болон дуудлага хүлээн авах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нарт холбогдо хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч, хариуцлага тооцохыг анхааруулсугай.

4. Албан даалгаврыг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, тайланг хагас, бүтэн жилээр Зөвлөгөө, мэдээллийн хэлтэст ирүүлж байхыг хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга наарт үүрэг болгосугай.

5. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР